

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

2020.02.13



**ТӨРИЙН АРХИВЫН БАРИМТУУДЫГ ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ,
ХАДГАЛАМЖИЙН САНГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Харьцуулалт/
гэрээний дугаар:**

Төрийн архивын баримтуудыг цахим хэлбэрт
шилжүүлэх, хадгаламжийн санг нэмэгдүүлэх
ДУАОНӨГ/202012033

Дархан
2020 он

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Төрийн архивын баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх, хадгаламжийн санг нэмэгдүүлэх, ДУАОНӨГ/202012033 дугаар бүхий тендерт бараа нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50.000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг 2020 оны 02 дугаар сарын 28–ны өдрийн 09 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 09 цаг 00 минутад нээнэ.

Уг тендер нь цахим худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтаар орж өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсэг, хувийн нууцлалын кодоор нэвтэрч www.tender.gov.mn сайтаар дамжуулан цахим хэлбэрээр ирүүлнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дархан-Уул аймаг, Орон нутгийн өмчийн газар,
Нутгийн удирдлагын ордон, 1 дүгээр давхар, 106 тоот өрөө
Утас/факс 7037-8104
www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерт оролцогчдын 2018, 2019 оны санхүүгийн тайлангаас шаардлагатай мэдээллийг цахим систем ашиглан шалгана.</p> <p><i>/Жич: 2019 оны санхүүгийн тайланг Сангийн яамны www.e-balance.mof.gov.mn цахим системд илгээж, харьяа бүртгэлийн мэргэжилтнээр баталгаажуулсан байна/</i></p> <p>2018, 2019 оны аль нэг жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх.</p> <p>2018, 2019 оны аль нэг жилд нийлүүлсэн ижил төстэй нийлүүлэлтийн гэрээний дүн санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх.</p> <p>Гэрээгээр нийлүүлсэн барааны гэрээний хуулбарыг нотлох баримтын хамт ирүүлнэ.</p> <p>Бусад нэмэлт шаардлага;</p> <ol style="list-style-type: none"> 1. Тендерт гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл ирүүлэх 2. Татвар болон харилцагч банкнаас тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлэх. 3. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай. 4. Нийлүүлэх техник хэрэгслийн техникийн болон ажиллагааны дэлгэрэнгүй тодорхойлолт, захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл заалт бүрээр нотлон харуулсан тайлбарын хамт эрх бүхий этгээд баталгаажуулж ирүүлнэ. 5. Гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотлох баримт бичиг /зээл авах баталгаажсан эрх болон боломжтой санхүүгийн бусад эх үүсвэр байж болно/ ирүүлнэ. Эргэлтийн хөрөнгийн дүн нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. <p>Уг тендер нь “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-аар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь “Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/ -д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа электрон /Adobe PDF/ хэлбэрт шилжүүлж цахим хэлбэрээ ирүүлнэ</p>
ТӨӨЗ 2.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг, Нутгийн удирдлагын ордон, Орон нутгийн өмчийн газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 дүгээр давхар, 106 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 28–ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p> <p>Хялбаршуулсан цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах</p>

	<p>эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Цахим тендер ашиглан илгээх нийт файл 10, 1 файлын хэмжээ 15 Mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантын системийг ашиглан төлнө.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг, Нутгийн удирдлагын ордон, Орон нутгийн өмчийн газар</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 дүгээр давхар, 106 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p> <p>Хялбаршуулсан цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.3	<p>Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үнийн саналын маягт, бараа нийлүүлэлтийн хуваарийг эрх бүхий этгээд баталгаажуулж ирүүлнэ 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатиар баталгаажуулж ирүүлэх 3. Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх газрын цахим тодорхойлолт ирүүлэх 4. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг <p><i>Дээрх материалуудыг нууцалж ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Төрийн архивын баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх, хадгаламжийн санг нэмэгдүүлэх, ДУАОНӨГ/202012033</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ


БАТЛАВ:
 ЗАСАГ ДАРГА  С.НАСАНБАТ



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:14


Архивын техник хэрэгсэл нийлүүлэх ажил

2020 он

Дархан-Уул аймаг

№	НЭР ҮЗҮҮЛЭЛТ	ТӨРӨЛ,	Зураг	ШААРДЛАГА
1	Зориулалт		Албан хэрэгцээнд /Аймгийн Архив/	
2	Стандарт		Бараа, материал, тоног төхөөрөмж нь олон улсын хэмжээнд болон Монгол улсад мөрдөж буй стандартын шаардлагыг хангасан байна.	
3	Техник, тоног төхөөрөмжийн байдал		Шинэ	
3.1	Компьютер /суурин/			Dell i5-8520 CPU 2.11 GHZ DDR IV RAM-8GB SSD-120GbHDD-1Tb Dell- 24 LCD Dell keyboard, mouse хамт, Тоо хэмжээ: 3ком
3.2	Хэвлэгч /3 үйлдэлтэй/			HP Laser jet M1005 MFP Тоо хэмжээ: 1ш
4	Тавилга эд хогшил		Шинэ	
4.1	Албан өрөөний сандал			Шинэ загварын чанартай, үзэмжтэй, Материал: Суудлын материал нь торон болон давуун, сандалын хийц төмөр Өнгө: Хар Түшлэгтэй, дугуйтай, 360 градус эргэдэг, өндөр болон налуургыг тохируулдаг байх Тоо хэмжээ: 3ш

4.2	Үйлчлүүлэгчдийн сандал		<p>Сандал нь төмөр 4 хөлтэй Суурь сайтай байх, Бат бөх шинэ загварын Суудал нь чанартай арьсан болон даавуун материалтай байж болно. Өнгө: Хар буюу шоколадан бор өнгөтэй байх</p> <p>Тоо хэмжээ: 10ш,</p>
4.3	Архивын ерөөний төмөр хаалга		<p>Бат бөх /Төмөр/, Үзэмжтэй, Цоожтой байх Шинэ загварын, Архивын стандартад нийцсэн байх Хэмжээ: 80x210мм Өнгө: Цагаан Тоо хэмжээ: 2ш</p>
4.4	Архивын нягтруулсан шүүгээ		<p>Хэмжээ : Урт 850-900 мм Өндөр 2300-2330 мм Өргөн 500-520 мм Өнгө: Цагаан саарал өнгөтэй Материал: Тавиур тавцангийн төмрийн зузаан 0.8-1,2 мм Шүүгээний багана болон хаалганы төмрийн зузаан 0.8-1,2 мм Хүрдэн гар эргүүлэгтэй Дамжуулагч арааны төмөрлөгийн хатуулаг чанар өндөр Араа дамжуулах гинжийг хасах нэмэх боломжтой хийц бүхий Гагнуур авдаг ган төмөр гүйдэг замтай . Резинэн жийргэвчтэй нүүртэй, дуу чимээ багатай гүйлттэй. Түгжээ нь бат бөх чанар сайтай. Захиалагчийн шаардлагад бүрэн нийцсэн орчин үеийн өнгө дизайнтай. Ус чийг нэвтэрдэггүй Архивын бичиг баримт хадгалах зориулалттай. Тоо хэмжээ: 14ш</p>

4.5	Шилэн нүүртэй шкаф		Хэмжээ: 185*90*40см Шилэн нүүртэй Шинэ загвар хийцтэй Цоожтой байх Төмөр Тоо хэмжээ: 1ш
4.6	Агааржуулагч		28 м2 талбайг агааржуулна. / 9000 Btu/ Цагт 400 м3 агаарыг сэлгэнэ. Халуун болон хүйтнээр үлээдэг байх. Дууны түвшин 37 дВ- 50 дВ Хөргөөх бодис R140G- 0.63 kg Тоо хэмжээ: 1ш Гүйцэтгэгч нь Захиалагчид нийлүүлж суурилуулж хүлээлгэн өгнө.
5	Баримт үдэгч		A4 хэмжээтэй 250 хуудас үдэх чадвартай Тоо хэмжээ: 1ш
6	Цаасан устгагч машин		Delii/9923 220мм A4 5ш цаас устгах чавартай
7	Туршлага	Энэхүү ажилтай ижил төстэй ажлыг 1-ээс дээш удаа гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх.	
8	Зөвшөөрөл	Худалдаа, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх	
9	Чадамж	Сангийн яамны хар жагсаалтанд ороогүй байх	
10	Баталгаа	Ажил гүйцэтгэж хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 6-н сарын хугацаанд чанарын баталгаа шаардана.	
11	Урьдчилгаа	Санхүүжилтийн урьдчилгаа олгохгүй	
12	Төсөвт өртөг	25,000,000.0 төгрөг Үүнд Гааль, НӨАТ, Тээврийн зардал, Суурилуулалтын зардал орно/	

Хянасан: ХОХБТХэлтсийн дарга

П.Батсүх

Боловсруулсан: ХОХБТХэлтэс, аймгийн
Ерөнхий эдийн засагч

Б.Батсүх

1. Бараа хүргэх газар: Дархан-Уул аймаг, Дархан сум, АЗДТГ

2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
1	Компьютер /суурин/	3	Иж бүрдэл	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
2	Хэвлэгч /3 үйлдэлтэй/	1	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
3	Албан өрөөний сандал	3	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
4	Үйлчлүүлэгчдийн сандал	10	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
5	Төмөр хаалга	2	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
6	Архивын нягтруулсан шүүгээ	14	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
7	Шилэн нүүртэй шкаф	1	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
8	Агааржуулагч	1	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
9	Баримт үдэгч	1	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	
10	Цаас устгагч машин	1	ш	АЗДТГ	Гэрээ байгуулснаас хойш	2020.05.01	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойл олт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Компьютер /суурин/			Иж бүрдэл				
Хэвлэгч /3 үйлдэлтэй/			ш				
Албан өрөөний сандал			ш				
Үйлчлүүлэгчдийн сандал			ш				
Төмөр хаалга			ш				
Архивын нягтруулсан шүүгээ			ш				
Шилэн нүүртэй шкаф			ш				
Агааржуулагч			ш				
Баримт үдэгч			ш				
Цаас устгагч машин			ш				
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:
Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|----------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. **6 сар**
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹
- 9.1. Алданги оногдуулах хувь: **0.05**
- Алдангийн нийт дүн: **10**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.